



Сувилахуйн сургуулийн 1-р дамжааны оюутнуудын цахим сургалтын сэтгэл ханамж

Буянжаргал Туул¹, Цанлигрэнчин Дашдулам², Болдбаатар Одгэрэл³, Дамдинжав Лхагвасүрэн⁴, Пүрэвсүрэн Золжаргал⁵, Баярхүү Лхагвасүрэн⁶ Пунцаг Орхонтуяа^{7*}
Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Сувилахуйн Сургууль,
¹Эх барих эх хүүхдийн сувилахуйн тэнхим, ²Анагаахын суурь шинжлэх ухааны тэнхим, ⁶79 дугаар сургууль
^{3, 4, 5, 7}Ерөнхий эрдмийн тэнхим

*Холбоо барих зохиогч: orkhontuya@mnums.edu.mn

Хүлээн авсан: 2021.01.28

Хянагдсан: 2021.06.16

Зөвшөөрсөн: 2021.06.21

Хураангуй

Дэлхийн улс орны их, дээд сургуулиуд сүүлийн жилүүдэд цахим сургалтын систем түлхүү ашиглаж байна. Ковид-19 цар тахлын улмаас Монголын их, дээд сургуулиуд 2019-2020 оны хичээлийн жилийн 2-р улирлаас эхлэн цахим байдлаар хичээллэж, багшлах хэв маяг өөрчлөгдөж байна. Энэхүү судалгааны зорилго нь оюутнуудын цахим сургалтад хандаж буй сэтгэл ханамж ба түүнд нөлөөлөх хүчин зүйлийг судлахад оршино. АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн 1-р дамжааны 321 оюутан судалгаанд хамрагдаж, судалгааны асуумжийг Google form дээр боловсруулж, судалгааг цахимаар хүлээн авсан. Сэтгэл ханамж ба түүнд нөлөөлөх хүчин зүйлийн хамаарлыг Пирсоны тестийг (хамаарлын коэффициент) ашиглан судлав. Судалгааны үр дүнгийн үзүүлэлтээс харахад оюутнуудын сэтгэл ханамж сургалтын материалд (4.16), оюутны оролцоонд (4.15) хамгийн их сэтгэл хангалуун, цахим хичээлийн технологи (3.25) шалгуурт хамгийн бага үзүүлэлттэй байна. Үүнээс үүдээд цахим сургалтын чанарт ахиц гаргах, хичээлийн технологид шинэчлэл хийх дидактик шаардлага үүсэж байна. Оюутнуудын сэтгэл ханамжийн түвшин үнэлгээтэй шууд хүчтэй эерэг ($r=0.65$), хичээлийн технологийн хүртээмжтэй шууд сул эерэг ($r=0.38$) хамааралтай ($p<0.001$) байсан төдийгүй цахим сургалтын сэтгэл ханамжийн оноо нь сургалтын чанар, сургалтын материалын хангамж, үнэлгээ, оюутны оролцоотой шууд хамааралтай байгаа нь ажиглагдлаа ($p<0.001$).

Түлхүүр үг

Цахим сургалт, сэтгэл ханамж, сургалтын материал, үнэлгээ

Удиртгал

Коронавируст халдварын улмаас дэлхийн улс орнуудын их, дээд сургуулийн уламжлалт сургалтыг цахим хэлбэрт хурдацтайгаар шилжүүлж байна. Цахим сургалтын хэлбэрт шилжүүлсэнтэй зэрэгцэн багшлах хэв маяг өөрчлөгдсөн нь

дээд боловсролын сургалтын чанарт шууд нөлөөлж болзошгүй байна. Цахим сургалтын суурийг 1800-аад оны үед Англид тавьсан бөгөөд багш, оюутан хоёр ердийн шуудангаар сургалтын үйл ажиллагаанд оролцдог байжээ. Цахим сургалтыг интернэт, мэдээлэл, харилцааны технологийг ашиглан явуулснаар танхимд биечлэн ирэх боломжгүй оюутнуудад мэдлэг, боловсролыг түгээдэг. Харин Монгол улсад зайн сургалтыг хөгжүүлэх, цаашлаад бүрэн тогтолцоог хөгжүүлэх эхлэл тавигджээ (Догсом, 2018 оны 5-р сарын 21, до.2). Цахимаар боловсрол олгох нь шинэ зүйл биш бөгөөд дээд боловсролын салбарт 2002 оноос цахимаар боловсрол олгож эхэлсэн. Харин манай улсад Ковид-19-ийн халдвартай холбоотой Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу 2019-2020 оны хичээлийн жилийн хоёрдугаар хагасыг 100 хувь цахимаар судлуулж өндөржүүлсэн (Мөрөн, 2020 оны 8-р сарын 11, до.4). 2013 онд судлаач Н.Мөнхцэцэг нар цахим сургалтын программ хангамжийн дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг болох цахим сургалтын системийн сонголт болон цахим номын сан тэдгээрийн хооронд мэдээлэл солилцох боломж бүхий модулиудын тухай судалжээ. Цахим хичээлийн сэтгэл ханамжийн болон агуулгын чанарын талаар судалгаа авсан. Ингэхэд судалгаанд оролцогчдын 82.5 хувь нь цахим хичээлд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн байна. Мөн 82 хувь нь цахим хичээлийн агуулга чанар сайн байсан гэж үнэлсэн гэлээ. Түүнчлэн хичээл сургалтыг цахимд шилжүүлснээр оюутнууд үзсэн агуулгаа бататгах, лавшруулан судлах зэргээр бие даан суралцах идэвх нэмэгдсэн талаар Г.Батнэмэх илтгэлдээ онцолжээ (Мөрөн, 2020 оны 8-р сарын 11, до. 5, 6). Монгол улсын боловсролын салбарт цахим сургалтын сэтгэл ханамжийн судалгаа хийгдэж буй боловч анагаахын оюутнуудын цахим сургалтын сэтгэл ханамжийн судалгаа хомс байв. Тиймээс бидний судалгааны зорилго нь Сувилахуйн Сургуулийн 2021 оны 1-р семестрт суралцаж буй оюутнуудын цахим сургалтын сэтгэл ханамж, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг судлахыг зорьсон.

Цахим сургалтын сэтгэл ханамж, түүнд нөлөөлөх хүчин зүйлс

Цахим сургалтын сэтгэл ханамжийг үнэлсэн олон улсын судалгаанууд хийгдсээр байна. Зайны боловсролын нэг төрөл болох цахим сургалтыг ашиглах нь сүүлийн хорин жилийн хугацаанд эрс нэмэгдсэн нь технологийн дэвшил нөлөөлсөн гэж үзэв (Beqiri, Chase, & Bishka, 2010, х.95-100). Цахим сургалт нь цаг хугацаа, байгаа газраас үл хамааран уян хатан суралцах, бие даан мэдлэг олгох боломжоор хангадаг. Мөн цахим сургалтаар суралцаж буй оюутнууд сургалтын давуу талыг хүссэн газраасаа суралцах боломж, уян хатан цагийн хуваарь, хямд зардал гэж тодорхойлсон байв (Leonard & Guha, 2001, х.51-57). Байгаа газраасаа үл хамааран хаанаас ч холбогдох боломжтой, өөрийн хэмнэлээр ажиллах, оюутнуудад багшийнхаа асуултад хариулахаас өмнө материал уншин судлан тэдгээрийн хариултыг эргэцүүлэн бодох боломжийг, олгодог (Berge, 1997, х.3-21). Харин оюутнууд бие даалтаа өөрөө удирдана, ингэснээр өөрт илүү таатай, нийцтэй аргаараа суралцах боломжийг өөртөө нэмэгдүүлдэг байна (Navarro & Shoemaker, 2000, х.15-35), (Ortiz, 2005, х.97-105). Судалгаагаар цахим сургалтын үед оюутнуудын багшаас тэр даруй асуулт асууж, харилцан ярилцах боломж хязгаарлагдмал болохыг олж тогтоов (Moore, 1991, х.1-6). Зарим судлаачид 35-55 насны оюутнууд цахим сургалтыг үр дүнтэй болох талаар судалжээ. Гэхдээ цахим сургалтын үеэр эмэгтэй оюутнууд багшийн заах арга барил нь маш чухал гэж үзсэн бол харин эрэгтэй оюутнууд багш нарын зохион байгуулах ур чадварыг маш чухал гэж үзжээ (Abdulla, 2004, х.167). Бусад судлаачдын судалгааны үр дүнгээс харахад цахим сургалтын оролцогчдын 25 ба 30 насныхан дийлэнх хувийг эзэлж байжээ (Schneider & Germann, 1999, х.37-48), (Talent- Runnels, & et.al, 2006, х.93-135),

(Wang, 2004, x.108-117). Бас цахим болон танхимын сургалтын харьцуулсан үр дүн, оюутнуудын зарим хүн ам зүйн үзүүлэлт (нас, хүйс болон үндэс, угсаа) зэргээр ялгаатай эсэхийг судалж тогтоов (Baglione & Nastanski, 2007, x.139-150). Гэсэн ч зарим судалгаагаар цахим сургалтад оюутнуудын нас, хүйс нь цахим хичээлийн сэтгэл ханамжид нөлөө үзүүлээгүй гэж тогтоожээ (Walker & Kelly, 2007, x.309-319). Оюутны сэтгэл ханамжийн судалгааны үр дүн нь цахимаар дамжуулж буй сургалтын хөтөлбөрийн чанарыг тодорхойлох маш сайн үзүүлэлт юм. Оюутнуудын цахим сургалтын хөтөлбөрт сэтгэл ханамжийн талаарх тойм судалгааны ажлууд хийгдсээр байна (Banks & Faul, 2007, x.780-793), (Dibiase & Rademacher, 2005, x.139-158). Судлаачид оюутнуудын цахим сургалтад сэтгэл ханамжийг олон талаас нь судалжээ (Aman, 2009, x.11), (Evans, 2009, x.13). Оюутны сэтгэл ханамжийг судлахдаа 1) цахим сургалтын үр дүн, 2) үнэлгээ 3) сургалтын материал 4) оюутны оролцоо 5) хичээлийн технологи гэсэн таван хүчин зүйлийг тус бүрээр авч үзсэн. Тэрээр оюутнуудын сэтгэл ханамжийг 1-ээс 5 хүртэлх Ликертийн хэмжүүрээр хэмжсэн ба цахим сургалтын ерөнхий сэтгэл ханамжийн дундаж оноо нь 4.21 (стандарт хазайлт = 0.96) байв (Aman 2009, x.11). Оюутны сэтгэл ханамжид нөлөөлдөг цахим хичээлийн бусад чухал хүчин зүйлийг судлаач нар судалж тогтоов. Оюутнуудын цахим сургалтад сэтгэл ханамжтай байх нь 1) Сургуулийн зүгээс оюутны санал хүсэлт, асуултад хариулах, 2) сургалтын нөөц, 3) сайн программ хангамж, 4) техникийн дэмжлэг үзүүлэх гэх мэт нь цахим сургалтыг оюутны сэтгэл ханамжид ээргээр нөлөөлдөг гэв (Ortiz-Rodriquez 2005, x.97-105). Зарим судлаачдын судалгааны үр дүнгээс харахад 1) багш нарын оролцоо, 2) сургалтын хөтөлбөр, 3) оюутны оролцоо, 4) уян хатан байдал, технологи зэрэг нь оюутны сэтгэл ханамжид орж байв (Evans, 2009, x.13). Судалгаанд хамрагдсан оюутнуудын талаас илүү хувь нь (54%) оюутнууд ба багштай сайн харилцаатай байх нь оюутны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх чухал хүчин зүйл болдог гэж үздэг (Mandernach, 2005, x.1-10). Энэхүү судалгаа нь бусад судлаачдын үр дүнтэй ижил төстэй байв. Оюутнуудын дийлэнх нь цахим сургалтад сэтгэл хангалуун байсан нь уян хатан цагийн хуваарьтай холбоотой байсан гэж үзсэн (Seaberry, 2008, x.8). Их Британи улсын их, дээд сургуулиудын цахим сургалтын системд хамрагдсан 563 оюутнаас авсан мэдээллийг хэсэгчилсэн хамгийн бага квадрат Бүтцийн тэгшитгэлийн загварчлал (PLS-SEM)-ын тоон аргаар цуглуулсан өгөгдөлд дүн шинжилгээ хийв. Судалгаанд оролцогчдын цахим сургалтын сэтгэл ханамжийн хувь нь 71.4%, түүнд нөлөөлдөг гол хүчин зүйлүүдэд техникийн системийн чанар, мэдээллийн чанар, үйлчилгээний чанар, оюутнуудын чанар, багшийн заах ур чадвар зэрэг багтаж байсан (Al-Fraihat 2019, x.67-86). Цахим сургалтын сэтгэл ханамжийн судалгаанд нийт бизнесийн удирдлагын 611 оюутнуудыг хамруулан судалгааны ажил хийсэн. Судалгааны үр дүнд X, Y, Z үе оюутнуудын цахим сургалтын хэлбэр, дамжаа, цахим хичээлийг хүргэж буй байдал зэрэгт сэтгэл ханамж ялгаатай байв. Судалгааны үр дүнд дээрх үеүдийн цахим сургалтын сэтгэл ханамж өндөр байв (Yawson & Yamoah, 2020, x.1-9).

Судалгааны түүвэр

Судалгааг зорилтот түүврийн аргаар АШУҮИС-ийн Сувилахуйн Сургуулийн 1-р дамжааны 2020-2021 оны хичээлийн жилийн 1-р семестрт суралцаж байгаа 321 оролцогчдыг хамруулав. Судалгаанд сувилагчийн ангийн 124, тусгай мэргэжлийн 197 оролцогч тус тус хамрагдав.

Судалгаанд хамрагдсан оюутнуудын дийлэнх нь буюу 76.6 хувь нь танхим болон цахимын сургалтыг хослуулсан бол 21.5 хувь нь дан ганц цахим сургалтад, харин дөнгөж 1.9 хувь нь дан ганц танхимын сургалтад хамрагдсан байна.

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийг хүснэгт 1-д харуулсан ба 88.5 хувь нь эмэгтэй оюутан, 11.5 хувь нь эрэгтэй оюутан хамрагдсан болно. Харьяаллын хувьд оролцогчдын 42.1 хувь нь хөдөө орон нутгийн, 57.9 хувь нь хотын оюутнууд байв. Оюутнуудыг мэргэжлийн чиглэлээр нь авч үзвэл сувилагч мэргэжилтэн 38.6 хувь, тусгай мэргэжилтэн 61.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 1

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Хүйс	Тоо (Хувь)
Эмэгтэй	284 (88.5)
Эрэгтэй	37 (11.5)
Харьяалал	
Хот	186 (57.9)
Хөдөө	135 (42.1)
Мэргэжил	
Сувилагч	124 (38.6)
Тусгай	197 (61.4)

Судалгааны мэдээлэл цуглуулсан аргачлал

Бид судалгаанд хамрагдсан оролцогчдоос цахим сургалтын сэтгэл ханамжийн судалгааг явуулахдаа Аманы ангиллыг ашиглав. Үүнд: цахим сургалтын үр дүн, үнэлгээ, сургалтын материал, оюутны оролцоо, хичээлийн технологи зэрэг багтана. Оролцогчдын цахим сургалтын сэтгэл ханамжийн талаарх хүчин зүйлийг (1-маш муу, 2-муу, 3-дунд, 4-сайн, 5-маш сайн) 5 онооны Ликертийн хэмжүүрээр үнэлэв. Судалгааны асуумжийн үнэн зөв буюу найдвартай байдлыг шалгах үүднээс асуумжийн бүлэг тус бүрд найдвартай байдлын шинжилгээ хийж Кронбахын альфа утгыг тодорхойллоо. Кронбахын альфа нь дотоод найдвартай байдлыг хэмждэг ба энэ нь бүлэг мэдээллийн хэр зэрэг нягт байгааг харуулдаг. Альфа коэффициент нь 0-1 хооронд утгатай байх ба $\alpha \geq 0.70$ байвал үнэн магадлал стандартад хүрсэн гэж үзнэ (Kane, 2004, х.136-146).

Судалгааны статистик боловсруулалт

Судалгаанд оролцогчдын цахим асуулгын үр дүнд статистик боловсруулалт хийж, дундаж утгын статистик магадлал бүхий ялгааг 95 хувийн итгэх хязгаараар баталгаажуулав. Оролцогчдын цахим сургалтын талаарх сэтгэл ханамжийн хоорондын хамаарлын коэффициентыг судлан боловсруулав. Нэмэлтээр судалгаанд оролцогчдын цахим сургалтын хэлбэр, хичээлийн техник хэрэгслийн талаарх судалгааг хувиар тооцоолон гаргасан.

Судалгааны үр дүн

Сувилахуйн Сургуулийн 1-р дамжааны оюутнуудын цахим сургалтын сэтгэл ханамж: Сувилахуйн сургуулийн 1-р дамжааны оюутнуудын 21.5 хувь нь цахимаар хичээлдээ судалсан бөгөөд ихэнх нь буюу 87.2 хувь нь цахим хичээлдээ гар утас ашиглаж байна. Энэхүү судалгаагаар цахим сургалтын оюутны сэтгэл ханамж бусад судалгааны үр

дүнтэй ойролцоо өндөр, дундаж утга нь 3.89 байна. Дундаж утгыг авч үзэхэд, оюутнууд сургалтын материал (4.16), оюутны оролцоонд (4.15) хамгийн их сэтгэл хангалуун байгаа бол цахим хичээлийн технологит (3.25) сэтгэл хангалуун байдал нь хамгийн бага байна (Хүснэгт 2). Тус үр дүн нь цахим сургалтын чанарыг сайжруулахын тулд хичээлийн технологийг шинэчлэх нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Хүснэгт 2

Оюутнуудын цахим сургалтын сэтгэл ханамжийн судалгаа

Хүчин зүйл	Доод утга	Дээд утга	Дундаж	СХ
Хичээлийн технологи	3.13	3.36	3.2523	1.05558
Оюутны оролцоо	4.08	4.22	4.1558	0.65243
Цахим сургалтын үр дүн	3.93	4.1	4.0218	0.78032
Үнэлгээ	3.77	3.94	3.8598	0.81527
Сургалтын материал	4.08	4.24	4.1651	0.69428
Дундаж оноо	3.79	3.97	3.89086	0.799576

СХ - стандарт хазайлт

Хүснэгт 3-т цахим сургалтын сэтгэл ханамжийн хувьсагчийн хамаарлыг харуулав. Судалгаанаас харахад оюутнуудын сэтгэл ханамжийн түвшин үнэлгээтэй шууд хүчтэй эерэг ($r=0.65$) хамааралтай, хичээлийн технологийн хүртээмжтэй шууд сул эерэг ($r=0.38$) хамааралтай байсан төдийгүй цахим сургалтын сэтгэл ханамжийн оноо нь сургалтын чанар, сургалтын материалын хангамж, үнэлгээ, оюутны оролцоотой шууд хамааралтай байгаа нь ажиглагдлаа ($p<0.001$).

Хүснэгт 3

Оюутнуудын цахим сургалт ба сэтгэл ханамжийн хоорондын хамаарал

	1	2	3	4	5	6
Цахим сургалтын сэтгэл ханамж	1					
Хичээлийн технологи	.386**	1				
Оюутны оролцоо	.590**	0.065	1			
Цахим сургалтын үр дүн	.619**	-0.045	.398**	1		
Үнэлгээ	.654**	0.034	.482**	.486**	1	
Сургалтын материал	.648**	0.041	.419**	.587**	.527**	1
Цахим асуумжийн найдвартай байдал						Кронбахын α 0.7
Ач холбогдлын зэрэг 0.01** түвшинд						($p<0.001$)

Кронбахын α -гийн утгыг цахим асуумжийн асуулт тус бүрд тооцоход 0.7 гарсан учир асуумж найдвартай, хоорондоо уялдаатай, сэтгэл ханамжийг үнэлж чадсан буюу үнэн магадлал стандартад хүрсэн гэж үзэж байна.

Дүгнэлт

Судалгааны үр дүнгийн үзүүлэлтээс харахад оюутнуудын сэтгэл ханамж сургалтын материалд (4.16), оюутны оролцоонд (4.15) хамгийн их сэтгэл хангалуун, цахим хичээлийн технологи (3.25) шалгуурт хамгийн бага үзүүлэлттэй байна. Үүнээс үүдээд цахим сургалтын чанарт ахиц гаргах, хичээлийн технологид шинэчлэл хийх дидактик шаардлага үүсэж байна.

Талархал

Тус судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд хамтран ажилладаг АШУҮИС-ийн Сувилахуйн Сургуулийн Байгалийн Ухааны болон Суурь Шинжлэх Ухааны багийн багш нартаа талархал илэрхийлье.

Ном зүй

- Abdulla, A. G. (2004). Distance learning students' perceptions of the online instructor roles and competencies. *Dissertation*. United States
- Aman, R. R. (2009). Improving student satisfaction and retention with online instruction through systematic faculty peer review of courses. *Dissertation*. United States
- Al-Fraihat, D., Joy, M., & Sinclair, J. (2020). Evaluating E-learning systems success: An empirical study. *Computers in Human Behavior, 102*, 67-86.
- Baglione, S. L., & Nastanski, M. (2007). The superiority of online discussion: Faculty perceptions. *Quarterly Review of Distance Education, 8*(2), 139-150.
- Banks, A. C., & Faul, A. C. (2007). Reduction of Face-to-Face Contact Hours in Foundation Research Courses: Impact on Students' Knowledge Gained and Course Satisfaction. *Social Work Education, 26*(8), 780-793.
- Beqiri, M. S., Chase, N. M., & Bishka, A. (2009). Online course delivery: An empirical investigation of factors affecting student satisfaction. *Journal of Education for Business, 85*(2), 95-100.
- Berge, Z. L. (1997). Computer conferencing and the on-line classroom. *International Journal of Educational Telecommunications, 3*(1), 3-21.
- Dibiase, D., & Rademacher, H. J. (2005). Scaling up: Faculty workload, class size, and student satisfaction in a distance learning course on geographic information science. *Journal of Geography in Higher Education, 29*(1), 139-158.
- Evans, T. (2009). An investigative study of factors that influence the retention rates in online programs at selected state, state-affiliated, and private universities. *Dissertation*. United States
- Kane, K. (2004). Quality matters: Inter-institutional quality assurance in online learning. *Sloan-C View: Perspectives in Quality Online Education, 3*(11), 136-146.
- Leonard, J., & Guha, S. (2001). Education at the crossroads: Online teaching and students' perspectives on distance learning. *Journal of Research on Technology in Education, 34*(1), 51-58.
- Mandernach, B. J., Donnelly, E., Dailey, A., & Schulte, M. (2005). A faculty evaluation model for online instructors: Mentoring and evaluation in the online classroom. *Online Journal of Distance Learning Administration, 8*(3), 1-10.
- Moore, M. G. (1991). Distance education theory. *The American Journal of Distance Education, 5*(3), 1-6.
- Navarro, P., & Shoemaker, J. (2000). Performance and perceptions of distance learners in cyberspace. *American journal of distance education, 14*(2), 15-35.
- Ortiz-Rodriguez, M., Teig, R., Irani, T., Roberts, T. G., & Rhoades, E. (2005). College students' perceptions of quality in distance learning. *The Quarterly Review of Distance Education, 6*(2), 97-105.
- Schneider, S. P., & Germann, C. G. (1999). Technical communication on the Web: A profile of learners and learning environments. *Technical communication quarterly, 8*(1), 37-48.
- Seaberry, B. J. (2008). A case study of student and faculty satisfaction with online courses at a community college. *Dissertation*. United States
- Tallent-Runnels, M. K., Thomas, J. A., Lan, W. Y., Cooper, S., Ahern, T. C., Shaw, S. M., & Liu, X. (2006). Teaching courses online: A review of the research. *Review of educational research, 76*(1), 93-135.

- Walker, C. E., & Kelly, E. (2007). Online instruction: Student satisfaction, kudos, and pet peeves. *Quarterly Review of Distance Education*, 8(4), 309-319.
- Wang, W. (2004). How university students view online study: A PCP perspective. *Campus-Wide Information Systems*, 21(3), 108-117.
- Yawson, D. E., & Yamoah, F. A. (2020). Understanding satisfaction essentials of E-learning in higher education: A multi-generational cohort perspective. *Dissertation*. United States
- Догсом, Г. (2018 оны 5 21). *Montsame*. Зайн сургалт нь зардал хэмнэхээсээ илүү чанартай мэргэжилтэн бэлдэхэд чухал ач холбогдолтой. : <https://montsame.mn/en/read/90502-ээс> Гаргасан. Улаанбаатар
- Мөрөн, Г. (2020 оны 8 11). *ikon.mn*. Г.Батнэмэх: Судалгаанд оролцогчдын 82.5% нь их, дээд сургуулийн цахим хичээлд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн: <https://ikon.mn/n/1yh3>"-ээс Гаргасан.Улаанбаатар
- Н. Мөнхцэцэг, Д. Г. (2013). Цахим сургалтын орчин. *Цахим засаглал, Мэдээллийн технологи сэтгүүл*, 14-18. Улаанбаатар

Satisfaction with E-Learning Among First-Year Students of the Nursing School

Tuul Buyanjargal¹, Dashdulam Tsanligrenchin², Odgerel Boldbaatar³, Lkhagvasuren Damdinvaj⁴, Zoljargal Purevsuren⁵, Lkhagvasuren Bayarhuu⁶, Orkhontuya Puntsag^{7*}
School of Nursing, Health Science University of Mongolia

¹Department of midwife, maternal and child nursing Basic Medical Sciences,

²Department of Basic Medical Sciences, School of Nursing,

^{6,7,9} school, ^{3,4,5,7}Department of Basic Science, School of Nursing,

*Corresponding author: orkhontuya@mnums.edu.mn

Received: 1/28/2021/

Revised: 6/16/2021

Accepted: 6/21/2021

Abstract

Universities around the world have been using e-learning systems in recent years. Due to the Covid-19 pandemic, all Mongolian universities are changing the way they teach online starting from the second term of the 2019-2020 academic year. The main objective of the research was to study the satisfaction and factors influencing the satisfaction with e-learning among first-year students of the School of Nursing. A total of 321 first-year students of the School of Nursing of the Mongolian University of Science and Technology were involved in the online survey. The survey questionnaire was developed using a Google form. The relationship between satisfaction and the factors influencing it was studied using the Pearson test (correlation coefficient). On average, students are most satisfied with the learning materials (4.16) and student participation (4.15), while those with e-learning technology (3.25) are the least satisfied. Therefore, in order to improve the quality of e-learning, it is necessary to improve the technology of the course. The study found that student satisfaction was directly positive ($r = 0.65$) with the assessment, and directly weak ($r = 0.38$) with the availability of course technology ($p < 0.001$). It was observed that e-learning satisfaction scores are directly related to the quality of training, supply of training materials, assessment, and student participation ($p < 0.001$).

Keywords

E-learning, Satisfaction, Students, Training materials, Assessment